



43  
Ж-09-39-01

ДАРХАН-УУЛ АЙМАГ  
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

13 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/200

Дархан

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн  
ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 25 дугаар зарлигийн 2-р хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Дарханы дулааны сүлжээ" ТӨХК-ийн "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралт №1-ээр баталсугай.
2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хэргийн хяналтын тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомж, энэхүү журмыг гүйцэтгэж ажиллан төлөвлөгөөнд заасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, холбогдох салбар зөвлөлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг Зөвлөлийн дарга /Ц.Алтанцэцэг/-нд даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.ГАНТУУЛ

## “ДДС” ТӨХК-ийн ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмын зорилго нь “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд баримтлах зарчим, зарчмын дарга, гишүүдийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

“Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс “Зөвлөл гэх” нь Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9.1-д зааснаар байгууллагын хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах үүргийг гүйцэтгэнэ.

Зөвлөл нь орон тооны бус, байнгын ажиллагаатай байна.

“ДДС” ТӨХК-ийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь өөрийн үйл ажиллагаандаа хамтын шийдвэр гаргах, ил тод, шуурхай, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

Зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Прокурорын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Хяналтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг баримтлах болгон ажиллана.

### Хоёр. Зөвлөлийн зохион байгуулалт

1. “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж тушаалаар батална.
2. Зөвлөл нь ажлын төлөвлөгөөгөө жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хуралдаанаар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж гүйцэтгэх захирлаар батлуулсан ажлын төлөвлөгөөний нэг хувийг Дархан-Уул аймгийн Прокурорын газарт үргүүлнэ.
3. Зөвлөлийг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга даргалах ба нарийн бичгийн дарга хуулийн зөвлөх байна.
4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх ба зөвлөлийн дарга хуралдааныг даргална. Зөвлөлийн даргын эзгүйд түүний даалгаснаар аль нэг гишүүн хуралдааныг даргална.
5. Зөвлөлийн хуралдаан нь ээлжит болон ээлжит бус гэсэн хэлбэртэй байна.
6. Зөвлөлийн ээлжит хуралдааныг сард нэг удаа зохион байгуулах ба зөвлөлийн гишүүдийн олонхи нь хуралдаанд оролцсоноор хүчинтэйд тооцно.
7. Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэх ба санал хураалт тэнцсэн тохиолдолд даргалагчийн саналыг харгалзан үзнэ.
8. Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг дарга, гүйцэтгэх удирдлага, гишүүдийн гуравны олонхийн санаачлагаар хуралдуулна.
9. Зөвлөлийн гишүүн ажлын төлөвлөгөөний дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөр хийсэн ажлын тайлан, үйл явц, үр дүнг хуралдаанд бэлтгэж танилцуулах ба энэ тайлангаар зөвлөлийн гишүүд хэлэлцэн шийдвэр гаргана.
10. Зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл гарах бөгөөд түүнд дарга, нарийн бичгийн

гарын үсэг зурна. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг холбогдох албан тушаалтан  
жүүлэх талаар арга хэмжээ авч, түүний явц, үр дүнг тогтоосон хугацаанд зөвлөлийн  
даанд танилцуулах үүрэгтэй.

11. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны тэмдэглэлийг ажлын 2 өдөрт багтаан  
даргаар хянуулан ба хуралдаан даргалагч, гишүүд гарын үсэг зурж  
гаажуулна.

12. Хуралдааны тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

12.1. Хуралдаан болсон огноо, эхэлсэн, дууссан цаг минут

12.2. Хуралдаан болсон газар

12.3. Хуралдааны ирц, хуралдаанд оролцоогүй гишүүдийн нэр, шалтгаан

12.4. Хэлэлцсэн асуудал, түүнийг танилцуулсан этгээдийн нэр, албан тушаал

12.5. Хэлэлцсэн асуудалтай холбогдуулан зөвлөлийн гишүүдээс тавьсан асуулт,  
хариулт, санал, дүгнэлт, хурлаас гарах шийдвэр

13. Зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн  
тайлангаа улирал тутам гүйцэтгэх захиралд, хагас жил тутамд Дархан-Уул аймгийн  
хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Дархан-Уул аймгийн  
нурорын газарт цаасан хэлбэрээр тус тус тайлагнах ба жилийн ажлын тайланг оны  
12 дугаар сарын 20-ны өдрийн дотор гүйцэтгэх захирал, Дархан-Уул аймгийн Гэмт  
хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Дархан-Уул аймгийн  
нурорын газарт тус тус хүргүүлнэ.

14. "ДДС" ТӨХК-ийн гүйцэтгэх удирдлага нь зөвлөлийн бүрэлдэхүүнийг ажиллах  
номж, нөхцлөөр хангана.

#### **Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг**

3.1. Зөвлөл нь дор дурьдсан үүрэгтэй:

3.1.1. Байгууллагын үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэртээ гэмт хэрэг гарч  
гаа шалтгаан нөхцлийг арилгах талаар хууль, хяналтын байгууллагуудтай хамтран  
иллах

3.1.2. Байгууллагын ажилтнууддаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор  
нбогдох хууль тогтоомжийг хууль, хяналтын байгууллагуудтай хамтран сурталчлан  
ниулах, мэдээ сургалт зохион байгуулах

3.1.3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль, хяналтын  
игууллагуудаас зохион байгуулах хамтын ажиллагааг зөвлөлийн ажилтай уялдуулан  
тарч зохион байгуулах

3.1.4. Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль, хяналтын  
игууллага, бусад байгууллагаас ирүүлсэн албан бичиг, саналын дагуу төлөвлөгөө  
ган хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах

3.1.5. Зөвлөлөөс зохион байгуулж байгаа ажлын үйл явц, үр дүнгийн талаар  
цэтгэх удирдлага, ажилтнуудад мэдээлэх

3.1.6. Байгууллагын нутаг дэвсгэр дээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн  
н журам сахиулах, сахилга хариуцлагыг сайжруулах талаар санал боловсруулан гаргаж,  
налаа хууль, хяналтын байгууллагад уламжлах

3.1.7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажилтнууддаа шинээр  
тлагдан гарсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл сургалт зохион байгуулах

3.1.8. Зөвлөлөөс зохион байгуулж байгаа арга хэмжээний талаар өөрийн  
игууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр мэдээ мэдээлэл танилцуулж  
йршуулах

3.1.9. Байгууллагын нутаг дэвсгэрийн хүрээнд Цагдаагийн газраас зохион байгуулах ажил эргүүлд байгууллагын ажилтнуудыг идэвхитэй хамруулж оролцуулах, түүнд туслах тавих

3.2. Зөвлөл нь дор дурьдсан эрхтэй:

3.2.1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон ажиллуулшгүй мэдээ мэдээллийг хэвлэл, мэдээллийн байгууллагад өгч, яаралтай шалтгаан олж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах

3.2.2. Бусад байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн сайн ажлын хэргийг судлах, түүнийг өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх

3.2.3. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан ажилтнуудын тушаалтанд хариуцлага тооцуулах талаар гүйцэтгэх удирдлагад санал гаргах

3.2.4. Байгууллагын ажилтнуудын дунд болон бусад байгууллагын ажилтнуудыг оролцуулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тэмцээн уралдаан зохион байгуулах

3.2.5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, тэмцээн уралдаан зохион байгуулах, танилцуулга, брошур хэвлүүлэхэд шаардагдах зардлыг батлуулж зарцуулах

3.2.6. Ажилтнуудын зүгээс гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх талаар хууль, хяналтын байгууллага, Дархан-Уул аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлд санал, шаардлага тавих

#### **Дөрөв. Зөвлөлийн дарга, гишүүний эрх, үүрэг**

4.1. Зөвлөлийн гишүүн нь зөвлөлийн хуралдаанаар асуудал хэлэлцүүлэх, танилцуулга зохиох, хуралдаанаас гарсан шийдвэрийг заасан хугацаанд биелүүлэх, танилцуулах

4.2. Зөвлөлийн дарга нь зөвлөлийг тэргүүлж, хуралдааныг товлон, даргалж явуулах, Дархан-Уул аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллах, зөвлөлийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих

4.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэр биелэлтийг хуралдааны тэмдэглэлийн биелэлтийг хангуулж ажлыг зохион байгуулах, гишүүдийн ажлын хэргийг хуралдаанд бүрдүүлэх, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг материалыг гишүүдэд хүргэх, хуралдаанаас 2 хоногийн өмнө тараах, хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зөвлөлийн ажлыг уялдуулан зохицуулах

#### **Тав. Хариуцлага**

5. Зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь хууль тогтоомж, энэхүү журмыг зөв биелүүлсэн тохиолдолд хөдөлмөрийн дотоод журам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

----- оОо -----